УХТЭ дээр Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлэх талаар хийгдсэн үйл ажиллагааны танилцуулга

С.Энхболд, Ц.Ганзориг, Ц.Билэгтсайхан, З.Аръяасүрэн, Б.Дулмаа, Т.Цэндсүрэн, Н.Баярмаа, Х.Болор, Ц.Уянга, М.Орхон, Д.Энхцэцэг, Ж.Уламсайхан, Б.Гантулга, Ш.Гансаруул, Х.Ганбаатар, Н.Эрхүү, Г.Тунгалаг, Д.Мөнхзул, Б.Бумдэлгэр

Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг
Цахим хаяг: Ts.uyanga87@gmail.com

Түлхүүр үг:

Коронавируст халдвар
Халдвараас сэргийлэх

Товч утга: 2019 оны 12 дугаар сарын сүүлчээс Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хубей мужийн Ухань хотод шалтгаан тодорхойгүй уушгины хатгаа өвчний дэгдэлт бүртгэгдэж, 2020 оны 1 дүгээр сарын 7-нд шинэ төрлийн коронавирус (SARS-CoV-2)-ээр үүсгэгдсэн болохыг тогтоосон. 2020 оны 1 дүгээр сарын 31-ний байдлаар уг халдвар нь дэлхийн 20 улсыг хамарч эрчимтэй тархсан тул ДЭМБ-аас “Олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал” хэмээн зарлаж, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр “Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал бүртгэгдсэн” гэж үзлээ. Монгол Улсын Засгийн газар 2017 оны Гамшгаас хамгаалах тухай хуулийг үндэслэн 2020 оны 1-р сард Улсын Онцгой Комиссыг ажиллуулав. Үүний үр дүнд нийгмийн эрүүл мэндийн талаар янз бүрийн арга хэмжээ авч, КОВИД-19-ийн анхны батлагдсан тохиолдол 2020 оны 3-р сарын 10 хүртэл илрээгүй. Улсын Хоёрдугаар Төв Эмнэлгийн “Гамшгийн Штаб”-ын зүгээс КОВИД-19 халдварын эсрэг зохион байгуулж хэрэгжүүлж буй үйл ажиллагааг энд танилцуулж байна.

Үндэслэл: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын мэргэжлийн зөвлөх багийн 2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар уг халдварыг “COVID-19” хэмээн нэрлэж олон улсын өвчний 10 дугаар ангиллаар U07.1 кодоор бүртгэж байна[1,2,3,4].

ДЭМБ-ын мэдээллээр 2020 оны 10 дугаар сарын 19-ны байдлаар дэлхийн 215 улсад коронавируст халдвар (COVID-19)-ын 37,109,851 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, 1,070,355 хүн нас барсан[5,6,7]. Монгол улсад уг өвчний зөөвөрлөгдөн ирсэн 315 батлагдсан тохиолдол бүртгэгдсэн[8].

Олон улсын эрүүл мэндийн дүрэм (2005)-ийн дагуу Коронавируст халдвар (COVID-19)-ын үед шуурхай хариу арга хэмжээ авах, тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна. УХТЭ-ийн Гамшгийн штабын бүрэлдэхүүн дараах үйл ажиллагааг явуулсан байна.

1. Удирдлага зохион байгуулалт: УХТЭ-ийн захирлын 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/08 тоот “Шинэ коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангаж ажиллах ажлын хэсэг зохион байгуулах тухай” тушаал, Эмнэлгийн захирлын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Шинэ коронавирусын халдварын тохиолдлын үеийн бэлэн байдлыг хангаж ажиллах тухай” А/09 дугаар тушаалын дагуу 4 эмч, 4 сувилагч, 4 үйлчлэгч, 1 ариутгагч нарыг тусгаарлах хэсэгт ажиллахаар томилсон. Мөн тусгаарлах хэсгийг 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр хүртэл ажиллуулсан байна. 2020 оны 02 дугаар сарын 04-ны өдөр эмнэлгийн хэмжээнд ашиглах боломжтой ipc.sgh@gmail.com хаяг нээж мэдээллээ цаг тухай бүрт нь гүүгл драйв дээр байршуулж байна. Тус хаяг нь эмнэлгийн ажилтан бүрт нээлттэй юм. Коронавируст халдварын дэгдэлтээс сэргийлэх ажлын төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр 2 чиглэл 57 заалт бүхий ажлын төлөвлөгөөг эмнэлгийн захирлаар батлуулан ажиллаж байна. ЭМС-ын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/99 дугаар тушаалын дагуу Эмнэлгийн Гамшгаас хамгаалах штаб өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж ажиллаж байна. Эмнэлэг дэлгэх үед эмнэлэг дээр Гамшгийн штаб